



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Зэсгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.03.15 № 3/457
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Даланзадгадын дулааны цахилгаан станц" ТӨХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээний, өмчийн өөрчлөлтийн тайлан болон холбогдох тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

"Даланзадгадын дулааны цахилгаан станц" ТӨХК-ийн удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг хариуцлага хүлээнэ.

"Даланзадгадын дулааны цахилгаан станц" ТӨХК-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан нь үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар "Даланзадгадын дулааны цахилгаан станц" ТӨХК-ийн санхүүгийн тайлан, түүний тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлт, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан болно.


Аудитаар 323,4 сая төгрөгийн алдаа, 45,5 сая төгрөгийн гаалийн татвар, НӨАТ, мөн 32,1 сая төгрөгийн ХХОАТ, НДШ суутгаагүй зэрэг нийт 266,7 сая төгрөгийн материаллаг зөрчилтэй санхүүгийн тайлан бэлтгэсэн нь санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Дээрх алдаа зөрчлийг эс тооцвол "Даланзадгадын дулааны цахилгаан станц" ТӨХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон санхүүгийн тайлангийн тодруулгуудыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлж Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



“ДАЛАНЗАДГАДЫН ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:

YAG-ын САГ-ын дарга
Тэргүүлэх аудитор:
Ц.Наранчимэг
Утас: 261663
Аудит менежер: Я.Самбууням
Утас: 261885
Ахлах аудитор: Н.Батсайхан
Утас: 260512

Монгол Улсын Үндэсний
Аудитын Газар

Засгийн газрын IV байр
Улаанбаатар-46
Бага тойруу 6

Вэб хуудас: www.audit.mn

“Эйч Эл Би Монголиа Аудит” ХХК
Захирал: Ч.Энхтуяа
Утас: 99110581

Аудит менежер: М.Нурболат
Утас: 99027275
Ахлах аудитор: Л.Сайнжаргал
Утас: 99796873
Аудитор: И.Юмчиндулам
Утас: 99094533
Аудиторын туслах: Э.Билгүүн
Утас: 99703230
Сүхбаатар дүүрэг 1 дүгээр хороо
“Гурван гал” төв 6 давхар, 607 тоот
Цахим хаяг: www.HLBM.mn
И-мэйл: info@hlbm.mn

Аудитын тайлан

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Аудит хийсэн санхүүгийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Материаллаг байдал
6. Дотоод хяналт
7. Орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
8. Шилэн дансны тухай мэдээлэл
9. Олж тогтоосон гол эрсдлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Санал дүгнэлтийн үндэслэл
18. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2 заалт, 18 дугаар зүйлийн 18.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 дахь заалтыг тус тус үндэслэн “Даланзадгадын дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд (ҮАГ-САГ/2016/22/СТА-ГАК-ТӨХЭ) аудит хийлээ.

Аудитыг Компанийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн аудитын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Даланзадгадын дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн гаргасан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

“Даланзадгадын дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн удирдлага нь санхүүгийн тайлангаа СТОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

“Даланзадгадын дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 11 дүгээр сарын 7-ноос 2016 оны 11 дүгээр сарын 12-ний хооронд завсар үеийн аудит, 2017 оны 2 дугаар сарын 15-наас 3 дугаар сарын 10-ны хооронд төгсгөл үеийн аудит хийхээр төлөвлөн “Эйч Эл Би Монголиа Аудит” ХХК-ийн Аудит менежер М.Нурболат ахлагчтай аудитын баг хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

“Даланзадгадын дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2016 оны 3 дугаар сарын 3-нд “Эйч Эл Би Монголиа Аудит” ХХК-д ирүүлсэн байна.

“Эйч Эл Би Монголиа Аудит” ХХК нь 2016 оны 11 дүгээр сарын 7-ноос 2016 оны 11 дүгээр сарын 12-ний хооронд завсар үеийн аудит, 2017 оны 2 дугаар сарын 15-наас 3 дугаар сарын 14-ны хооронд эцсийн аудитыг гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 3 дугаар сарын 15-нд “Даланзадгадын дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн удирдлагад гардуулна.

2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

“Даланзадгадын дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн удирдлага нь Монгол улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Сангийн сайдын 2012 оны 77 тоот тушаалаар баталсан “Санхүүгийн тайлан бэлтгэх заавар, санхүүгийн тайлангийн маягтын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 2016.01.01-нээс шинэчлэгдэн мөрдөгдөж байна.

3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

“2018 оны түвшинд хүний хөгжлийг дээдэлсэн, техник технологио шинэчилсэн, ISO стандартын шаардлага хангасан ЭКО хамт олон болно” гэж байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

“Даланзадгадын дулааны цахилгаан станц” ТӨХК нь цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх, түгээх, дулааны эрчим хүч үйлдвэрлэх, түгээх, цахилгаан, дулааны эрчим хүчээр зохицуулалттай хангах зэрэг тусгай зөвшөөрлийн дагуу эрчим хүчний үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж байна.

Тус компани нь үндсэн үйлдвэрлэлийн ба үйлдвэрлэлийн бус гэсэн өртгийн төвтэй бөгөөд 148 ажиллагсадтай өдөр тутмын ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

“Даланзадгадын дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар “Даланзадгадын дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс тус компанийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5-З/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-З/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад “Даланзадгадын дулааны цахилгаан станц” ТӨХК санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг хамгийн сүүлд 2012 онд шинэчилсэн байна. Тиймээс 2016 оны 1 дүгээр сарын 1-ээс дагаж мөрдөхөөр шинэчлэгдсэн НӨАТ-ын тухай хуулийн дагуу үндсэн хөрөнгийн худалдан авалтанд хамаарах НӨАТ-ыг үндсэн хөрөнгийн өртөгт шингээхтэй холбоотой өөрчлөлтийг НББ-ын бодлогын баримт бичигт тусгаагүй байна.

“Даланзадгадын дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

“Даланзадгадын дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн Апекс програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайлан гаргасан байна.

5. Материаллаг байдал

Аудитаар материаллаг байдлын суурийг төлөвлөлтийн шатанд нийт зардал болох 4,546.7 сая төгрөгөөс 1 хувиар тооцон 45.5 сая төгрөгөөр материаллаг байдлын түвшинг тогтоосон бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөөгүй болно.

Материаллаг байдлын суурийг нийт орлогоос тооцоход өөрийн үйл ажиллагаанаас олсон орлого болон улсаас авсан санхүүжилт нь тус компанийн үйл ажиллагааны зардлыг нөхөж чадаагүй тул нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зүйтэй гэж үзэв.

6. Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. “Даланзадгадын дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

7. Орлого, зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

“Даланзадгадын дулааны цахилгаан станц” ТӨХК нь 2016 онд нийт гүйцэтгэлээрх орлого нь 2,359.1 сая төгрөг буюу төсөвлөгдсөн орлогоос 64.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.



Нийт гүйцэтгэлээрх зардал 4,546.7 сая төгрөг буюу төсөвлөгдсөн зардлаас 1.0 сая төгрөг хэмнэсэн нь түлшний зардлаас хэмнэсэн байна.



8. Шилэн дансны тухай мэдээлэл:

2015 оны 7 сарын 1-ний өдөр улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх,

түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоо /цаашид “шилэн данс” гэх/-г бүрдүүлэх зорилттой “Шилэн дансны тухай” хууль батлагдсан.

“Шилэн дансны тухай” хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтад эрчим хүчний төрийн өмчит компаниудыг хамруулж шилэн данс цэсэнд байршуулах мэдээллийг 3 дахин цөөрүүлж, 7 нэр төрлийн мэдээлэл оруулахаар болсон.

Монгол улсын ЭХЯ-ны сайд, дэд сайдын 2016 оны 9 дүгээр сарын 07, 12 дугаар сарын 23-ны өдрийн 1/2263, 6/3356 тоот, албан бичгээр “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах тухай” удаа дараа зөвлөмж, чиглэл өгсөн байна.

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ЭХЯ-ны хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2016 оны 11 дүгээр сарын 21-нээс 12 дугаар сарын 02-ны өдрийг хүртэлх хугацаанд шалгасан шалгалтаар “Даланзадгадын дулааны цахилгаан станц” ТӨХК 90 хувьтай шалгагдсан байна.

Тус компанийн шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэлд тандалт, шалгалт хийхэд зарим мэдээлэл тухайн байгууллагад хамааралгүй, эсвэл тухайн цаг үед байршуулах мэдээлэл байхгүй тохиолдолд тайлбар тодруулга хийгээгүй байгааг нөхөн тайлагнах цаашид хуулийн хугацаанд мэдээллээ бүрэн оруулж хэвшүүлэх зөвлөмж өгсөн.

9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 90 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 98 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

10. Гол, онцлог гүйлгээний талаарх:

“Даланзадгадын дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бусад орлого, бичиг хэрэг, тээвэр шатахуун, шуудан холбоо, төлбөр хураамж, сургалт семинар зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа.

2016 онд 60.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан мөн 205.2 сая төгрөгийн их засварын зардлыг капиталжуулах байснаас 11.7 сая төгрөгийн хөдлөх хөрөнгийн засвар үйлчилгээний зардлыг капиталжуулалтаар бүртгэн нийт 216.9 сая төгрөгөөр капиталжуулсан тул 11.7 сая төгрөгийг залруулах зөвлөмж өгсөн.

2016 оны ИЗ, ТЗБАХ, Хөрөнгө оруулалт



Гол түүхий эд 25.1 мянган тонн буюу 376.5 сая төгрөгийн эрчим хүчний нүүрсийг Энержи Ресурс ХХК-аас үнэ төлбөргүй авсан, 0.5 мянган тонн буюу 8.1 сая төгрөгийн нүүрсийг Таван толгой ХК-иас худалдан авсан байна. Дансны авлага нь 236.3 сая төгрөг буюу өмнөх оноос 16 хувь буюу 44,8 сая төгрөгөөр буурсан байна.

11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Аудитын явцад “Даланзадгадын дулааны цахилгаан станц” ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэж гаргах заавар, аж ахуй нэгж байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлалын дагуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байдал, дансны болон ерөнхий журнал, ерөнхий дэвтэр зэрэг хураангуй бичилтийг арга зүйн хувьд нягтлан үзэж санхүүгийн тайлангийн илэрхийлэлд үнэлэлт өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв.

Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. 2016 оны байдлаар тухайн оны худалдан авалтын төлөвлөгөөнд багтсан 7 төрлийн 167.3 сая төгрөгийн бараа материалыг олж бэлтгэхдээ ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д “харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар” гэснийг зөрчсөн.

Шийдвэрлэсэн: 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 4/152 тоот зөрчил арилгуулах албан шаардлага өгч энэхүү албан шаардлагын биелэлтийг 2017 оны 7 дугаар сарын 1-ны дотор ирүүлэхийг үүрэг болгосон. Цаашид хууль, тогтоомжийн холбогдох заалтыг мөрдөж ажиллахыг зөвлөсөн.

2. Импортоор 293.8 сая төгрөгийн бараа материал худалдан авахдаа гаалийн байгууллагад мэдүүлээгүй байгаа нь Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 7.1, НӨАТ-ын тухай хууль 7.1.2-г зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Дутуу тооцсон 14.7 сая төгрөгийн гаалийн татвар, 30.8 сая төгрөгийн НӨАТ-ыг тайлагнаагүй, санхүүгийн тайланд залруулаагүй. Цаашид дээрхи тогтоолын холбогдох заалтыг мөрдөж ажиллахыг зөвлөсөн.

3. Касс, харилцахын зарлагын гүйлгээгээр хувь хүнээс бараа худалдан авах, ажил гүйцэтгэх гэрээгээр олгосон ажлын хөлснөөс суутган тооцох ХХОАТ 16.8 сая төгрөг, НДШ 15.3 сая төгрөг, нийт 32.1 сая төгрөгийг дутуу тайлагнасан нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 11.1.1-11.1.6, 12.2, 13.1.2-13.1.4, 15.1-д заасан заалтуудын хүрээнд албан татварыг хуулийн хугацаанд ногдуулж, суутгасан татварыг холбогдох төсөвт төвлөрүүлж тайлагнах, Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1-д “Өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж байгууллага, төрийн бус, шашны болон бусад байгууллага, иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн

343, 359 дүгээр зүйлд заасан гэрээний дагуу Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн байдал: Менежментийн захидлаар ХХОАТ, НДШ-ийг нөхөн тооцож, санхүүгийн тайланд үнэн зөв тусгах талаар зөвлөмж өгсөн.

4. Эздийн өмчийн бусад хэсэгт бүртгэгдсэн 210.0 сая төгрөг нь 2006 оноос хойш Орон нутгаас ДзДЦС ТӨХК-нд үзүүлсэн хандив бөгөөд баримтыг үндэслэн НББОУС-20.15(а)-р стандартын дагуу орлогоор хүлээн зөвшөөрөх.

Шийдвэрлэсэн: Орон нутгаас ДзДЦС ТӨХК-нд үзүүлсэн хандив 210.0 сая төгрөгийг хуримтлагдсан ашгаар залруулаагүй. Цаашид СТОУС-ыг баримтлан мөрдөж ажиллахыг зөвлөсөн.

5. 2009 онд Сангийн Яамнаас баталсан гарын авлагын дагуу компанийн үндсэн хөрөнгийг дахин үнэлсэн бөгөөд түүнээс хойш дахин үнэлэгдсэн үндсэн хөрөнгөтэй холбоотой шилжүүлэлт, зарлага гарсан боловч үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансанд үндсэн хөрөнгийн хөдөлгөөнтэй холбоотой хэрэгжүүлэлтийг бүртгээгүй байна. Үүнд ТӨХ-ны 2013 оны 185 тоот тогтоолоор ӨБЦТС ТӨХК-нд шилжүүлсэн 2,336.9 сая төгрөгийн анхны өртөгтэй, 1,158.5 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй 1,178.4 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй хөрөнгө болон 2012 онд ТӨХ-ны 611 тоот тогтоолоор акталж данснаас хассан хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл нийт 29.9 сая төгрөгийг хуримтлагдсан ашиг руу хааж бүртгээгүй байна.

Шийдвэрлэсэн: НББОУС-16.41-ийн дагуу үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжилтийг хуримтлагдсан ашиг дансанд залруулж бүртгээгүй тул цаашид СТОУС-ыг баримтлан мөрдөж ажиллахыг зөвлөсөн.

Аудитын явцад материаллаг бус хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Конторын барилга, Хурлын заалны элэгдэл байгуулахдаа Эрчим хүчний зохицуулах хорооны 2016 оны 53 дугаар тогтоолыг мөрдөөгүйгээс 4.5 сая төгрөгийн элэгдлийн зардлыг илүү байгуулсан байна.

Шийдвэрлэсэн: Илүү тооцсон хуримтлагдсан элэгдлийг залруулаагүй тул цаашид дээрхи тогтоолын холбогдох заалтыг мөрдөж ажиллахыг зөвлөсөн.

2. Өмнөх онд өгсөн зөвлөмжөөр хөрөнгийн жагсаалтаас тээврийн хэрэгслийн баримт бичиг рүү хөөн шалгахад элэгдлээрээ өртгөө нөхсөн 3 чиргүүл, 1 краз машин, 1 эксковатор нийт 5 тээврийн хэрэгсэл байхгүй байв. Эдгээр хөрөнгийг данснаас хасуулахаар Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Эрчим хүчний Яам, Сангийн Яаманд удаа дараа албан тоотоор хандсан боловч тайлант хугацаанд хариу шийдвэр ирээгүй байна.

Шийдвэрлэсэн: Менежментийн захидлаар дахин зөвлөмж өгсөн.

3. 2016 оны Эрчим хүчний зохицуулах хорооны 208 дугаар тогтоолоор батлагдсан тарифын дагуу айл өрхөөс 10, албан байгууллагаас 10 харилцагчийг сонгож гэрээний шинэчлэлтийг шалгахад 40 хувьд гэрээг шинэчилж хийгээгүй байна.

Шийдвэрлэсэн: Менежментийн захидлаар зөвлөмж өгсөн.

4. Өмнөх жилийн аудитаар өгсөн зөвлөмжөөр тус компанийн мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй танилцахад дансны төлөвлөгөө нь Монгол Улсын Сангийн Сайдын 2005.01.12-ны өдрийн 07 дугаар тушаал “Эрчим Хүчний Салбарт Мөрдөх Дансны Жагсаалт, Заавар”-аас зарим дансны хувьд зөрүүтэй байсан нь хэвээр байна. Мөн хууль, тогтоомжийн өөрчлөлтийг НББ-ийн бодлогын баримт бичигт тусгаагүй байна. Жишээлбэл: 2016 оны 1 дүгээр сарын 1-ээс НӨАТ-ыг үндсэн хөрөнгийн өртөгт оруулахаар Нэмэгдсэн Өртгийн Албан Татварын хуульд тусгасныг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөн тусгаагүй байна.

Шийдвэрлэсэн: Менежментийн захидлаар дахин зөвлөмж өгсөн.

12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

1. 2011 оноос тухайн байгууллагаас салж үйл ажиллагаа явуулж байгаа Даланзадгадын Дулаан Хангамж ОНӨҮГ-т шилжүүлсэн 21.5 сая төгрөгийн авлагыг албан ёсоор хүлээлцсэн акт байхгүй гэсэн шалтгаанаар тооцоо нийлээгүй, 23-р цэцэрлэгийн авлага 3.6 сая төгрөгийг төсөв хүрэлцэхгүй гэсэн шалтгаанаар тооцоо нийлж, тулган баталгаажуулалт ирүүлээгүй.

Шийдвэрлэсэн: Энэ авлагын дүнг баталгаажуулахаар 2016 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 16/199, 2017 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн 17/034, 17/035 тоот албан бичгээр Өмнөговь аймгийн Үндэсний аудитын газарт хандсан. Менежментийн захидлаар зөвлөмж өгсөн.

2. Үндсэн хөрөнгөнд элэгдэл байгуулахдаа Эрчим хүчний зохицуулах хорооны 2016 оны 53 дугаар тогтоолыг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн: Менежментийн захидлаар зөвлөмж өгсөн.

13. Анхаарал татахуйц бусад чухал асуудлууд:

Турбингенератор №1-ийн талаар: Эрчим хүчний сайдын 2015 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн 102 тоот тушаалаар “Даланзадгадын ДЦС” ТӨХК-ийн гэмтсэн турбингенератор №1-ийн суурин дээр 3МВт-ийн хүчин чадалтай дулаацуулгын авлагатай турбингенератор худалдан авч суурилуулах ажлыг зохион байгуулах ажлыг хэсэг томилж, 2015.08.24-нд 2015/95 тоот ажлын даалгавар боловсруулан, холбогдох ажлын даалгаврыг Хүрэл Интернэшнл ХХК, Восток энерго монтаж ХХК,

Гкал ХХК, Энержи Девелопмент ХХК гэсэн 4 компани үнийн санал ирүүлэх албан тоот илгээсэн боловч, Гкал ХХК, Хүрэл Интернэшнл ХХК, Энержи Девелопмент ХХК-иудаас үнийн санал ирснийг 2015.09.14-ны Эрчим Хүчний Яамны хурлаар гүйцэтгэгч компанийг шалгаруулж, Хүрэл Интернэшнл ХХК 1,298.0 сая төгрөгөөр гүйцэтгэхээр шалгарсан.

Гэрээний дагуу 4 удаагийн төлбөр төлөлтөөр нийт 1,103.3 сая төгрөгийг Хүрэл Интернэшнл ХХК шилжүүлсэн бөгөөд гэрээний нөхцөлийн дагуу гэрээний үнийн дүнгийн 15% буюу 194.7 сая төгрөгийг шилжүүлээгүй байна.

Засвар угсралтын ажлыг 2016 оны 4 дүгээр сарын 26-аас 2017 оны 2 дугаар сарын 24-нийг хүртэл нийт 6 удаагийн туршилт тохируулга хийсэн боловч амжилтгүй болж 2017 оны 2 дугаар сарын 24-нд роторын гэмтлийг үйлдвэрийн аргаар засварлахаар гэрээлэгч компани БНХАУ руу авч явсан.

Дээрх байдлаар удаа дараагийн гэмтэл гарсан тул уг хөрөнгийг одоо болтол хүлээн аваагүй байгаа нь компанид их хэмжээний хохирол үүсэх эрсдэлийг бий болгож байна.

14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

“Даланзадгадын дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

“Даланзадгадын дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар 266.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн ба дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх талаар удирдлагад анхааруулж, 139.5 сая төгрөгийн 6 зөвлөмж, 127.2 сая төгрөгийн албан шаардлага өгсөн ба нийт 328.5 сая төгрөгийн 5 залруулга гарсан боловч, ерөнхий нягтлан бодогч гадаад руу албан томилолтоор явсан тул аудитын хугацаанд залруулаагүй болно.

16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

“Даланзадгадын дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2015 оны санхүүгийн тайлангийн аудитыг “Эйч Эл Би Монголиа Аудит” ХХК гүйцэтгэж 5 зөвлөмж өгсөн. Эдгээрээс 1 зөвлөмжийг хэрэгжүүлж, 4 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

17. Санал дүгнэлтийн үндэслэл

Аудитаар 323.4 сая төгрөгийн алдаа, 45,5 сая төгрөгийн гаалийн татвар, НӨАТ мөн 32,1 сая төгрөгийн ХХОАТ, НДШ суутгаагүй зэрэг нийт 266.7 сая төгрөгийн материаллаг зөрчилтэй санхүүгийн тайлан бэлтгэсэн нь санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, хэмжилт, үнэн зөв гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул дараах дүгнэлт өгсөн болно.

18. Хязгаарлалттай санал дүгнэлт

Дээрх алдаа зөрчлийг эс тооцвол “Даланзадгадын дулааны цахилгаан станц” ТӨХК -ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан болон тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, СТОУС түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан 4 хуудас, хавсралтууд 55 хуудсыг тус тус хавсаргав.



“ДАЛАНЗАДГАДЫН ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1

Асуудал 1

Бараа материалын талаар

Асуудал 2

Эздийн өмчийн талаар

Асуудал 3

Үндсэн хөрөнгийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

Асуудал 1

Татварын тооцооллын талаар

Асуудал 2

Мөнгөн хөрөнгийн талаар

Асуудал 3

Авлага, урьдчилж төлсөн
зардлын талаар

Асуудал 4

Нягтлан бодох бүртгэлийн
талаар

2017 он 3 дугаар сар

Менежментийн захидал

Манай аудитын баг аудит бүрийн төгсгөлд аудит болон бусад ажлаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг “Даланзадгадын дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмж өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Манай аудитын баг энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан “Даланзадгадын дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1: Бараа материал**Тэргүүлэх ач холбогдол №1**

Бодит байдал	Зөвлөмж
• 55 удаагийн худалдан авалтаар нийт 12.6 сая төгрөгийн бараа материалыг анхан шатны баримтгүйгээр данс бүртгэлд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчиж байна. • Бараа материалын худалдан авахтай холбоотой тээврийн зардал 34.5 сая төгрөгийг бараа материалын өртөгт оруулаагүй шууд өртөгт хүлээн зөвшөөрсөн нь НББОУС-2.11 “бараа материалын худалдан авалтын өртөгт худалдан авсан үнэ, импортоор хураамж болон бусад татвар (татварын эрх бүхий байгууллагаас дараагийн үеүдэд тухайн аж ахуйн нэгжид нөхөн олгохоос бусад), тээвэрлэлт, ачиж буулгах зардал болон бэлэн бүтээгдэхүүн, материал, үйлчилгээг худалдан авахтай шууд холбогдон гарах бусад зардлууд орно” гэсэн заалтыг зөрчиж байна.	• Анхан шатны баримтыг бүрдүүлэх, цаашид анхан шатны баримтгүйгээр ажил гүйлгээ хийхгүй байх. • НББОУС-2.11-ийг дагаж мөрдөж ажиллах. Цаашид хууль стандартын хэрэгжилтийг хангаж ажиллах.
Эрсдэл	Үйлчлүүлэгчийн хариу
• ТБОНӨХБАҮХА тухай хуулийг зөрчсөн нь зах зээлийн үнээс хэт өндөр үнээр худалдан авалт хийх эрсдэл үүснэ. • Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ыг мөрдөөгүйн улмаас санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг буруу илэрхийлснээр, шийдвэр гаргагчдын шийдвэрт нөлөөлөх эрсдэлтэй.	• Цаашид хэрэгжүүлэн ажиллах болно.

Асуудал 2: Эздийн өмч**Тэргүүлэх ач холбогдол №1**

Бодит байдал	Зөвлөмж
- Эздийн өмчийн бусад хэсэгт бүртгэгдсэн 210.0 сая төгрөг нь 2006 оноос хойш Орон нутгаас өмчөөс ДзДЦС ТӨХК-нд үзүүлсэн хандивын холбогдох нотлох баримтуудыг аудитын явцад аудитуруудад танилцуулаагүй. ДзДЦС-ын хувьцаа эзэмшигч нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар бөгөөд НББОУС-20.15(а) “засгийн газрын буцалтгүй тусламж нь хувьцаа эзэмшихээс өөр бусад эх үүсвэрээс хүлээн авсан орлого тул тэдгээрийг шууд хувьцаа эзэмшигчдийн дүнд кредитлэх ёсгүй, харин холбогдох тайлант үед нь ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрөх ёстой.” гэж заасныг зөрчсөн байна. - Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансанд ТӨХ-ны 2012 оны 611 тоот тогтоолоор актлагдсан болон дуудлага худалдаанд оруулан данснаас хассан хөрөнгө, мөн ТӨХ-ны 2013 оны 185 тоот тогтоолоор ДзДЦС ТӨХК-аас ӨБЦТС ТӨХК-нд балансаас баланст шилжүүлсэн хөрөнгөтэй холбоотой нийт 29.9 сая төгрөгийн дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжилтийг бүртгээгүй байна. Энэ нь НББОУС-16.41-д “Өмчийн дүнд багтсан дахин үнэлгээний хуримтлагдсан нэмэгдлийг хөрөнгийг данснаас хасах үед хуримтлагдсан ашигт шилжүүлж болно” гэж заасныг зөрчсөн байна.	- НББОУС-20.15(а)-д заасны дагуу холбогдох баримтуудыг бүрдүүлсний дараа санхүүгийн тайлангийн зорилгоор хуримтлагдсан ашиг дансанд хүлээн зөвшөөрөх. - НББОУС-16.41-д заасны дагуу Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ хийснээс (2009.12.31-ээс хойш) хойшхи данснаас хассан үндсэн хөрөнгийн гүйлгээг дахин нягтлан шалгаж, дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжилттэй холбоотой 29.9 сая төгрөгийн залруулга хийх.
Эрсдэл	Үйлчлүүлэгчийн хариу
- Эздийн өмчийн хэсэг СТОУС-ыг хэрэгжүүлээгүйгээс санхүүгийн тайлан үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх. - Эздийн өмчийн хэсэг буруу илэрхийлэгдэх эрсдэлтэй.	Өгсөн зөвлөмжийн хэрэгжүүлэн ажиллана.

Асуудал 3: Үндсэн хөрөнгө**Тэргүүлэх ач холбогдол №1**

Бодит байдал	Зөвлөмж
• Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн ерөнхий дэвтрийн үлдэгдэл дэлгэрэнгүй бүртгэлтэйгээ 34.2 сая төгрөгөөр зөрж байна. Энэ нь өмнөх оны аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэхдээ үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг буруу тооцсон хөрөнгийн ашиглалтын хугацааг хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд засахгүйгээр зөвхөн ерөнхий журналд холбогдох залруулгыг хийсэнтэй холбоотой байна. • 296.8 сая төгрөгийн анхны өртөгтэй 11 тээврийн хэрэгслийн ашиглалтын хугацаа ЭХЗХ-ны 2016.02.04-ны өдрийн 53 тоот тогтоолоор баталсан "Эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам"-д зааснаас зөрүүтэй байна. • Хөрөнгийн жагсаалтаас тээврийн хэрэгслийн баримт бичиг рүү хөөн шалгахад элэгдлээрээ өртгөө нөхсөн 3 чиргүүл, 1 краз машин, 1 эксковатор нийт 5 тээврийн хэрэгсэл байхгүй байв. • 11.7 сая төгрөгийн засвар үйлчилгээний зардлыг үндсэн хөрөнгөд капиталжуулсан нь НББОУС 16.12-ыг зөрчсөн байна.	• НББОУС-16-ийн дагуу үндсэн хөрөнгийн бүртгэлийг хөтлөх. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.3-т “дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх;” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллах. • “Апекс санхүүгийн програм”-д үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг засаж оруулах, Хөрөнгийн ашиглалтын хугацааны өөрчлөлттэй холбоотойгоор үүсэх зөрүүгийн НББ-ийн бичилтийг НББОУС-8 “НББ-ийн бодлогын өөрчлөлт ба алдааны залруулга” стандартын дагуу холбогдох бичилтүүдийг хийж залруулах. • НББОУС-16.12-ын дагуу үндсэн хөрөнгийн бүртгэлийг хөтлөх.
Эрсдэл	Үйлчлүүлэгчийн хариу
• Санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг буруу илэрхийлснээр шийдвэр гаргагчдын шийдвэрт нөлөөлөх эрсдэлтэй.	• Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Асуудал 1: Татварын тооцоолол**Тэргүүлэх ач холбогдол №2**

Бодит байдал	Зөвлөмж
- Иргэдээс худалдан авсан бараа, ажил үйлчилгээний үнийг олгохдоо холбогдох хуулийн дагуу НДШ-ийн суутгал 16.8 сая төгрөг, ХХОАТ-ийн суутгал 15.3 сая төгрөг нийт 32.1 сая төгрөгийг суутган тайлагнаагүй байгаа нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 11.1.1-11.1.6, 12.2, 13.1.2-13.1.4,15.1-д заасан заалтуудын хүрээнд албан татварыг хуулийн хугацаанд ногдуулж, суутгасан татварыг холбогдох төсөвт төвлөрүүлж, тайлагнах, Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1-д “Өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж байгууллага, төрийн бус, шашны болон бусад байгууллага, иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээний дагуу Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн” гэсэн заалтыг зөрчсөн байна. - Импортоор олж бэлтгэсэн 73 удаагийн нийт 293.8 сая төгрөгийн худалдан авалтыг гаалийн байгууллагад мэдүүлээгүй байгаа нь Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т “Мэдүүлэгч нь гаалийн бүрдүүлэлтийн тухайн горимд шаардагдах бичиг баримтыг үндэслэн гаалийн үнийг тодорхойлж, гаалийн байгууллагад мэдүүлэх ба ингэхдээ дурын, эсхүл зохиомол үнэ хэрэглэхийг хориглоно”, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2-т “гадаад улсаас Монгол Улсад импортоор оруулсан бүх төрлийн бараа, ажил, үйлчилгээнд нэмэгдсэн өртгийн албан татвар ногдоно” эдгээр хуулийн зүйл заалтуудыг зөрчсөн. - Импортоор үндсэн хөрөнгө бэлтгэхдээ гаалийн байгууллагад мэдүүлээгүй үндсэн хөрөнгийн гаалийн татвар 0.6 сая төгрөг болон НӨАТ 1.4 сая төгрөгийг хөрөнгийн өртөгт оруулан тооцоогүй байгаа нь НББОУС-	- Холбогдох татвар, нийгмийн даатгалын хуулийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах. Тайлант хугацаанд дутуу тооцоолсон суутгалыг тайлагнах. - Импортоор авсан материалд гаалийн татварыг нөхөн мэдүүлэх цаашид Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2-ийг дагаж мөрдөх. - НББОУС-16.16(а) заалтыг дагаж мөрдөх. Цаашид хуулийн холбогдох заалтыг мөрдөж татвар, хураамжийг тооцон өртөгт оруулан бүртгэж байх. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1,

16.16 “Үндсэн хөрөнгийн зүйлийн өртөг дараах зүйлээс бүрдэнэ: (а) гаалийн татвар, буцаан олгогдохгүй худалдааны татварын дүнг оруулсан худалдааны хөнгөлөлт, буцаалтыг хассаны дараах худалдан авалтын үнэ” гэсэн заалт, мөн Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 7.1.”Мэдүүлэгч нь гаалийн бүрдүүлэлтийн тухайн горимд шаардагдах бичиг баримтыг үндэслэн гаалийн үнийг тодорхойлж, гаалийн байгууллагад мэдүүлэх ба ингэхдээ дурын, эсхүл зохиомол үнэ хэрэглэхийг хориглоно.” Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 7.1.2 “гадаад улсаас Монгол Улсад импортоор оруулсан бүх төрлийн бараа, ажил, үйлчилгээнд нэмэгдсэн өртгийн албан татвар ногдоно” 14.1.5.”үндсэн хөрөнгө бэлтгэхэд зориулж импортоор оруулсан буюу худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн болон үндсэн хөрөнгө худалдан авахад төлсөн албан татварыг хасахгүй” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, 14 дүгээр зүйлийн 14.1.5 гэсэн заалтуудыг мөрдөн ажиллах. • Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын дагуу холбогдох өөрчлөлтийг НБББББ-т тусгах.
Эрсдэл • ААНОАТ-ын тухай хууль, ХХОАТ-ын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хуулиудыг зөрчсөнөөр татварын акт, торгууль тавигдах эрсдэлтэй байна. • Санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг буруу илэрхийлснээр шийдвэр гаргагчдын шийдвэрт нөлөөлөх эрсдэлтэй.	Үйлчлүүлэгчийн хариу • Өгсөн зөвлөмжийн хэрэгжүүлэн ажиллана. • Бараа материалын Гаалийн татвар болон НӨАТ-ын хувьд манай цахилгаан станцын хэвийн үйл ажиллагааг явуулахад шаардлагатай сэлбэг хэрэгсэл нь Монголд үйлдвэрлэдэггүй, ихэвчлэн импортоор оруулж ирдэг. Импортын сэлбэг хэрэгсэлтэй холбоотой татварын хуулийн аливаа хөнгөлөлт чөлөөлөлт эдлэх зүйл заалт бий эсэх талаар бид нар судлан ажиллах болно. Эрчим хүчний яам болон ЭХЗХ-оос татварын хөнгөлөлт чөлөөлөлтийн талаар асууж тодруулъя. Учир нь НӨАТ нь манай байгууллагын хувьд санхүүгийн дарамт учруулж байгаа татварын нэг юм.

Асуудал 2: Мөнгөн хөрөнгө		Тэргүүлэх ач холбогдол №2	
Бодит байдал		Зөвлөмж	
- Харилцахын төлбөрийн даалгаврыг санхүүгийн програмаас хэвлэдэггүй, урьдчилан дугаарладаггүй. - Кассын орлого, зарлагын баримтыг санхүүгийн програмаас хэвлэдэггүй, урьдчилан дугаарладаггүй. - Хас банкин дахь валютын харилцах дансны үлдэгдэл 981,51 ам долларын жилийн эцсийн ханшийн тэгшитгэл хийгээгүй.		- Харилцахаар гүйлгээ гарах бүрт урьдчилан дугаарлагдсан төлбөрийн даалгаврыг програмаас хэвлэж байх. - Кассаар бэлэн мөнгөний гүйлгээ гарах бүрт урьдчилан дугаарлагдсан орлого, зарлагын баримтыг програмаас хэвлэж байх. - Мөнгөн хөрөнгийн гүйлгээ, эцсийн үлдэгдлийг тухайн үеийн Монгол банкны албан ханшаар тооцож санхүүгийн тайланд тусгаж хэвших.	
Эрсдэл		Үйлчлүүлэгчийн хариу	
- Харилцах, кассын гүйлгээг гараар бичиж, цаг алдах техник ажил нэмэгдэх, мөнгөн кассын хадгалалт хамгаалалт хангалтгүйгээс мөнгө алдагдах - Монгол банкны албан ханшаар гадаад валютын ханшийн тэгшитгэл тооцоогүйгээс санхүүгийн тайлан буруу гарах - Холбогдох хууль тогтоомж, журам, заавар зөрчсөн байх		Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ	

Асуудал 3: Авлага, урьдчилж төлсөн зардал

Тэргүүлэх ач холбогдол №2

Бодит байдал	Зөвлөмж
• 2011 оноос тухайн байгууллагаас салж үйл ажиллагаа явуулж байгаа Даланзадгадын Дулаан Хангамж ОНӨҮГ-т шилжүүлсэн 21.5 сая төгрөгийн авлагыг албан ёсоор хүлээлцсэн акт байхгүй гэсэн шалтгаанаар тооцоо нийлээгүй, 23-р цэцэрлэгийн авлага 3.6 сая төгрөгийг төсөв хүрэлцэхгүй гэсэн шалтгаанаар тооцоо нийлж, тулган баталгаажуулалт ирүүлээгүй. • Нийт авлагын 48 хувь нь 1 жилээс дээш насжилттай ба НБББББ-ийн дагуу найдваргүй авлагын нөөц байгуулаагүй байна. • 2015-2016 оны дулааны авлагаас шүүхийн шатанд шууд төлөхөөр шүүгчид тайлбар гаргасан 2.1 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна. • Авлагын дансуудын ангилал буруу хийгдсэн байна.	• “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 70 дугаар зүйл болон “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д заасны дагуу авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах. • Авлага барагдуулах ажлын төлөвлөгөө гарган богино хугацаанд авлагаа барагдуулах, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” заалтын дагуу жилийн эцсийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах. НБББББ-т зааснаар авлагын насжилтийн судалгаанд үндэслэн найдваргүй авлагын хасагдуулгын нөөц байгуулах. ТУЗ-ийн хурлаар нөөц байгуулах хувийг батлуулж мөрдөх. • Шүүхээр шийдвэрлэх шатанд байгаа, авлагыг барагдуулж, дансанд тушаалгах, шүүхийн материал бүрдүүлснээс хойш үүссэн дулааны мөнгийг шүүхэд нэмж нэхэмжлэх, нэг жилээс дээш хугацаатай авлагыг шүүхээр шийдвэрлүүлэх ажлыг шуурхай зохион байгуулж, авлагаа барагдуулах • Авлагын ангиллыг залруулж, санхүүгийн тайланд үнэн зөв тусгах.

Гэрээ байгуулаагүйгээр иргэн Э.Билэгсайханд 2016.07.08-нд 7.0 сая төгрөгийг гэрээт ажлын хөлс гэсэн утгатайгаар Хас банкны данснаас шилжүүлсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно гэсэн заалтыг зөрчиж байна.	Холбогдох дүрэм журмын дагуу гэрээ байгуулах. Хийж гүйцэтгэсэн ажлыг баримтжуулан гэрээ дүгнэсэн акт үйлдэж хийсэн ажлыг хүлээн авах.
Эрсдэл	Үйлчлүүлэгчийн хариу
- Санхүүгийн тайлангийн үнэн зөв бодитой байх зарчмыг алдагдуулна. - Байгууллагын санхүүгийн хэвийн үйл ажиллагаа алдагдах, найдваргүй авлага нэмэгдэх. - Холбогдох хууль тогтоомж, журам, заавар зөрчсөн байх. - Санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг буруу илэрхийлснээр шийдвэр гаргагчдын шийдвэрт нөлөөлөх эрсдэлтэй.	Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

Бодит байдал	Зөвлөмж
Тус компанийн мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй танилцахад дансны төлөвлөгөө нь Монгол Улсын сангийн сайдын 2005.01.12-ны өдрийн 07 дугаар тушаал “Эрчим Хүчний Салбарт Мөрдөх Дансны Жагсаалт, Заавар”-аас зарим дансны хувьд зөрүүтэй, хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлээгүй байна.	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Монгол Улсын сангийн сайдын 2005.01.12-ны өдрийн 07 дугаар тушаалаар батлагдсан монгол улсын эрчим хүчний салбарын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагын мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны нэгдсэн жагсаалтын зааварт нийцүүлэн боловсруулж батлуулан үйл ажиллагаанд мөрдөж ажиллах.
Эрсдэл	Үйлчлүүлэгчийн хариу
Холбогдох хууль тогтоомж, журам, заавар зөрчсөн байх	Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

“Даланзадгадын дулааны цахилгаан станц” ТӨХК

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2016 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

Үзүүлэлт	1-р сарын 1	12-р сарын 31
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	62 939 800,88	271 793 946,94
Дансны авлага	281 144 198,02	236 327 828,11
Бараа материал	409 248 603,22	381 110 108,66
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	165 389 804,40	1 359 195 059,73
Эргэлтийн хөрөнгийн дүн	918 722 406,52	2 248 426 943,44
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	8 455 977 584,74	7 442 209 490,40
Биет бус хөрөнгө	6 991 304,00	4 660 864,00
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	8 462 968 888,74	7 446 870 354,40
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	9 381 691 295,26	9 695 297 297,84
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
Өр төлбөр		
Дансны өглөг	465 387 489,61	317 996 769,22
Татварын өр	64 073 273,78	156 956 756,55
НДШ-ийн өглөг	125 838 207,26	34 925 868,34
Богино хугацаат зээл	85 000 000,00	288 300,00
Хүүний өглөг	1 029 497 379,10	1 098 794 402,13
Урьдчилж орсон орлого	70 424 448,53	1 371 918 559,74
Бусад богино хугацаат өр төлбөр	243 733 381,44	189 687 676,30
Богино хугацаат өр төлбөрийн дүн	2 083 954 179,72	3 170 568 332,28
Урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат зээл	4 949 787 369,00	4 949 787 369,00
Бусад урт хугацаат өр төлбөр	242 813 765,00	242 813 765,00
Урт хугацаат өр төлбөрийн дүн	5 192 601 134,00	5 192 601 134,00
Өр төлбөрийн нийт дүн	7 276 555 313,72	8 363 169 466,28
Эздийн өмч		
Өмч: - төрийн	8 337 595 020,45	8 337 595 020,45
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3 058 535 855,13	3 058 535 855,13
Эздийн өмчийн бусад хэсэг	210 038 037,10	210 038 037,10
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	- 9 501 032 931,14	- 10 274 041 081,12
Эздийн өмчийн дүн	2 105 135 981,54	1 332 127 831,56
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	9 381 691 295,26	9 695 297 297,84

“Даланзадгадын дулааны цахилгаан станц” ТӨХК
АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

2016 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
Борлуулалтын орлого (цэвэр)	1 723 390 421,65	1 889 715 231,82
Борлуулалтын өртөг	3 836 929 621,07	3 926 760 860,83
Нийт ашиг (алдагдал)	(2 113 539 199,42)	(2 037 045 629,01)
Түрээсийн орлого	-	-
Хүүний орлого	1 863 687,11	3 910 921,91
Ногдол ашгийн орлого	-	-
Эрхийн шимтгэлийн орлого	-	-
Бусад орлого	2 056 616 435,86	1 919 461 495,46
Борлуулалт, маркетингийн зардал	-	-
Ерөнхий ба удирдлагын зардал	350 061 585,52	377 982 271,41
Санхүүгийн зардал	106 922 970,05	69 297 023,03
Бусад зардал	27 945 751,27	40 645 140,88
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	200 271,23	477 975,97
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
Бусад ашиг (алдагдал)	(147 952 152,33)	- 171 497 386,80
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(687 741 264,39)	(772 617 057,79)
Орлогын татварын зардал	186 368,71	391 092,19
Татварын дараах ашиг (алдагдал)	(687 927 633,10)	(773 008 149,98)
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(687 927 633,10)	(773 008 149,98)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
Бусад олз (гарз)	-	-
Орлогын нийт дүн	(687 927 633,10)	(773 008 149,98)

“Даланзадгадын дулааны цахилгаан станц” ТӨХК
АУДИТ ХИЙГДСЭН ЭЗДИЙН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
 2016 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт дүн
2014 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	8 337 595 020,45	3 058 535 855,13	210 038 037,10	(8 808 731 146,82)	2 797 437 765,86
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	(4 374 151,22)	(4 374 151,22)
Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	-	-	-	(687 927 633,10)	(687 927 633,10)
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8 337 595 020,45	3 058 535 855,13	210 038 037,10	(9 501 032 931,14)	2 105 135 981,54
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-	-
Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал				(773 008 149,98)	(773 008 149,98)
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8 337 595 020,45	3 058 535 855,13	210 038 037,10	(10 274 041 081,12)	1 332 127 831,56

“Даланзадгадын дулааны цахилгаан станц” ТӨХК

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2016 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

(тегрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
Мөнгөн орлогын дүн	3 481 834 109,61	3 662 364 433,01
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1 747 596 286,37	2 050 397 267,37
Татаас, санхүүжилтийн орлого	1 600 000 000,00	1 600 066 700,00
Бусад мөнгөн орлого	134 237 823,24	11 900 465,64
Мөнгөн зарлагын дүн	3 426 170 730,50	4 141 789 298,92
Ажиллагчдад төлсөн	1 211 558 917,54	1 440 850 873,16
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	176 796 519,78	445 000 000,00
Бараа материал худалдан авахад төлсөн	1 111 682 183,60	1 181 066 757,78
Ашиглалтын зардалд төлсөн	111 796 383,04	69 587 770,68
Түлш шатахуун, сэлбэг хэрэгсэлд төлсөн	340 416 511,37	381 371 025,01
Хүүний төлбөрт төлсөн	138 790,80	-
Татварын байгууллагад төлсөн	321 143 481,00	337 381 023,98
Даатгалын төлбөрт төлсөн	3 061 282,00	3 930 112,00
Бусад мөнгөн зарлага	149 576 661,37	282 601 736,31
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	55 663 379,11	(479 424 865,91)
Мөнгөн орлогын дүн	853 799,31	38 503 446,19
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	34 592 524,28
Хүлээн авсан хүүний орлого	853 799,31	3 910 921,91
Мөнгөн зарлагын дүн	40 000 000,00	822 691 990,60
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	40 000 000,00	822 691 990,60
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(39 146 200,69)	(784 188 544,41)
Мөнгөн орлогын дүн	-	1 472 467 556,38
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	174 467 556,38
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
Төрөл бүрийн хандив	-	1 298 000 000,00
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	1 472 467 556,38
Валютын ханшийн зөрүү	-	-
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	16 517 178,42	208 854 146,06
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	46 422 622,46	62 939 800,88
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	62 939 800,88	271 793 946,94